

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/002/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЗЗА ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Б.ГАЛБАДРАХ ТАНААХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРАЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/293

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр зам засвар арчлалтын компаниудад хэрэгжүүлсэн тээвэр хэрэгжүүлэх төслийн үр дүнд бий болсон 448,747.2 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авахдаа урт хугацаат зээл дансанд бүртгэснийг аудитын хугацаанд залруулсан.

Аудитын гол асуудал

Аудитаар зорилтот түвшинд батлагдсан нийт зардлыг хэтрүүлж ажилласан зөрчилд албан шаардлага хүргүүлж, авлага барагдуулах, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, анхан шатны баримтын бүрдэл болон ахмадын сантай холбоотой 4 зөвлөмжийг хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг АЗЗА ТӨХК-тай байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

671192084

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,156,318.73	215,110.79
1.1.02	Дансны авлага	188,852,531.83	334,008,102.50
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	22,133,306.26	86,711.00
1.1.04	Бусад авлага	32,008,214.46	32,008,214.46
1.1.06	Бараа материал	190,134,473.00	155,385,562.73
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	434,284,844.28	521,703,701.48
1.2.01	Үндсэн хөрөнгө	677,690,409.57	626,294,257.73
1.2.02	Биет бус хөрөнгө	0.00	2,583,333.35
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	8,932,753.07	8,932,753.07
1.2.09	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	208,004,600.00	208,004,600.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	894,627,762.64	845,814,944.15
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,328,912,606.92	1,367,518,645.63
2.1.1.01	Дансны өглөг	151,994,105.60	423,922,934.62
2.1.1.02	Цалингийн өглөг	7,920,000.00	11,809,679.90
2.1.1.03	Татварын өр	159,345,029.77	172,719,674.71
2.1.1.04	НДШ - ийн өглөг	126,103,699.87	135,574,775.51
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	445,362,835.24	744,027,064.74
2.1.2.01	Урт хугацаат зээл	448,747,239.00	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	448,747,239.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	894,110,074.24	744,027,064.74
2.3.01	Өмч: - төрийн	669,879,751.09	669,879,751.09
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	33,609,027.31	33,954,977.31
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	379,135,071.00	827,882,310.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-647,821,316.72	-908,225,457.51
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-611,906,438.59	-260,404,140.79
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-35,914,878.13	-647,821,316.72
2.3.11	Эздийн өмчийн дүн	434,802,532.68	623,491,580.89
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,328,912,606.92	1,367,518,645.63

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,471,744,201.46	1,356,226,692.05
02	Борлуулалтын өртөг	1,810,569,637.70	1,355,082,358.63
03	Нийт ашиг(алдагдал)	-338,825,436.24	1,144,333.42
10	Ерөнхий ба удирдлагын зардал	253,154,002.35	261,548,474.21
12.1	Зардлын дүн	253,154,002.35	261,548,474.21
17	Бусад ашиг (алдагдал)	-19,927,000.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	-19,927,000.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-611,906,438.59	-260,404,140.79
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-611,906,438.59	-260,404,140.79
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-611,906,438.59	-260,404,140.79

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	669,879,751.09	33,609,027.31	377,935,071.00	-35,914,878.13	1,045,508,971.27
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-611,906,438.59	-611,906,438.59
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	1,200,000.00	0.00	1,200,000.00
09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	669,879,751.09	33,609,027.31	379,135,071.00	-647,821,316.72	434,802,532.68
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	448,747,239.00	0.00	448,747,239.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	827,882,310.00	0.00	827,882,310.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-260,404,140.79	-260,404,140.79
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	345,950.00	0.00	0.00	345,950.00
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	669,879,751.09	33,954,977.31	827,882,310.00	-908,225,457.51	623,491,580.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/Төгрөгөөр/</i>			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,746,148,520.23	1,295,683,315.62
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,744,436,512.00	1,294,513,759.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	155,259.00	312,516.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,556,749.23	857,040.62
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,846,328,380.37	1,256,071,579.56
1.2.1	Ажиллагчдад төлсөн	571,325,113.06	646,075,643.81
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	81,403,173.45	153,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	377,478,960.00	122,209,013.67
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	231,864,764.54	56,893,024.82
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	397,741,618.55	171,122,847.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	102,503,757.77	95,415,550.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,508,373.00	148,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	81,502,620.00	11,207,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-100,179,860.14	39,611,736.06
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	100,749,893.08	49,446,596.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	99,510,893.08	49,446,596.00
2.1.8	Бусад	1,239,000.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,042,613.00	67,300,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	880,000.00	64,990,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	2,310,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	16,162,613.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	83,707,280.08	-17,853,404.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	214,070,000.00	35,745,200.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	214,070,000.00	35,745,200.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	202,429,898.15	58,444,740.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	202,429,898.15	58,444,740.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,640,101.85	-22,699,540.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-4,832,478.21	-941,207.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,988,796.94	1,156,318.73
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,156,318.73	215,110.79

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д.д	Үзүүлэлт	2024		Харьцуулалт	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Хувь	зөрүү /2024 гүйц-2024 төл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	1,263,264,800.0	1,356,226,692.1	107.4	92,961,892.1
	а/ Улсын чанартай зам засвар арчлалт	1,093,764,800.0	1,353,384,157.3	123.7	259,619,357.3
	б/Орон нутгийн чанартай зам засварын ажил	168,000,000.0	-	-	(168,000,000.0)
	в/ Бусад орлого	1,500,000.0	2,842,534.8	189.5	1,342,534.8
2	НИЙТ ОРЛОГО	1,263,264,800.0	1,356,226,692.1	107.4	92,961,892.1
3	НИЙТ ЗАРДАЛ	1,247,818,700.0	1,616,630,832.8	129.6	368,812,132.8
	Үүнээс: Удирдлагын зардал	289,441,600.0	261,548,474.2	90.4	(27,893,125.8)

4	Татварын өмнөх ашиг	15,449,000.0	(260,404,140.8)	(1,685.6)	(275,853,140.8)
5	Цэвэр ашиг /алдагдал/	13,904,200.0	-	-	(13,904,200.0)
	Төсвийн төлбөрт нийт дүн	263,368,200.0	248,415,550.2	94.3	(14,952,649.8)
	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	5,340,000.0	-	-	(5,340,000.0)
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	91,000,000.0	65,568,871.8	72.1	(25,431,128.2)
	Ус ашигласны төлбөр	-	-	-	-
	Газрын төлбөр	988,500.0	1,760,910.0	178.1	772,410.0
	Агаарын бохирдлын төлбөр	120,000.0	84,500.0	70.4	(35,500.0)
	Тээврийн хэрэгслийн татвар	980,000.0	944,514.0	96.4	(35,486.0)
	ЭМНДШ	106,898,200.0	153,000,000.0	143.1	46,101,800.0
	Үл хөдлөхийн татвар	1,800,000.0	425,000.0	23.6	(1,375,000.0)
	ХАОАТ	56,241,500.0	22,482,670.0	40.0	(33,758,830.0)
	Бусад	-	4,149,084.4	-	4,149,084.4
7	Төрийн өмчийн ноогдол ашигт	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	34.0	31	91.2	(3.0)
9	Нийт цалингийн сан	737,229,000.0	672,136,920.7	91.2	(65,092,079.3)
10	Нэг ажилтны дундаж цалин	1,806,933.8	1,806,819.7	100.0	(114.1)
13	Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	0.99	1.19	120.7	0.2
14	Хөрөнгө оруулалт	65,900,000.0	67,900,000.0	105.0	2,200,000.0
15	НИЙТ АВЛАГА	213,000,000.0	366,103,028.0	171.9	153,103,028.0
	Үүнээс:Найдваргүй				-
16	НИЙТ ӨГЛӨГ	608,747,239.0	744,027,064.7	122.2	135,279,825.7
	Үүнээс: Богино хугацаат	160,000,000.0	744,027,064.7	465.0	584,027,064.7
	урт хугацаат	448,747,239.0	0.0	100.0	448,747,239.0)

3. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар нийт 448,747.2 мянган төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залрууллаа. Үүнд:

1. Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр зам засвар арчлалтын компаниудад хэрэгжүүлсэн тээвэр хэрэгжүүлэх төслийн үр дүнд бий болсон 448,747.2 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авахдаа Засгийн газрын тогтоолыг зөрчиж урт хугацаат зээл дансанд бүртгэсэн алдааг Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэж залруулсан.

Аудитаар нийт 400,820.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 368,812.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

3.3 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй холбоотой:

1.1 Илрүүлэлт:

Нийт зардлын гүйцэтгэл 1,616,630.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 368,812.1 мянган төгрөгөөр буюу 29.6 хувиар хэтэрсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 "Захирал дараах эрх, үүрэгтэй: ...үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах...", АЗЗАН ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/59 дүгээр тушаал, Компанийн дүрмийн 8.9.4 " Төлөөлөн Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн албан шаардлага:

Батлагдсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын дансанд 2014 онд үүссэн 32,008.2 мянган төгрөгийн бусад авлага бүртгэлтэй байна. Тус авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тус авлагыг барагдуулах бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд буй газрын бүртгэлд тусгахдаа тоо хэмжээг 1, нэгжийн үнэлгээг нийт үнээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх, 5.1.5.хэмжигдэхүйц байх гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Бодит тоо хэмжээ, нэгжийн үнээр бүртгэлд тусгах

1.1 Илрүүлэлт:

Шатахууны зарцуулалтад түүвэрлэн хяналт хэрэгжүүлэхэд жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогчоор бодуулж, холбогдох албан хаагчаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Шатахууны тооцооны хуудсыг цаг тухай бүр бүрэн бодож, хянуулж ажиллах

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

4.1 Илрүүлэлт:

Хөвсгөл АЗЗА ТӨХК нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сан байгуулж ажиллах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/	
				Үүнээс	
				Залруулсан	Залруулаагүй

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
УХӨТ залруулсан	1	448,747.2			1	448,747.2	1	448,747.2		
Дүн	1	448,747.2			1	448,747.2	1	448,747.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага барагдуулаагүй	1	32,008.2					1	32,008.2				
Жолоочийн тооцооны хуудас бодоогүй	1						1	0.0				
Газрын бүртгэлтэй холбоотой	1						1	0.0				
Бизнес төлөвлөгөөний зардал хэтрүүлсэн.	1	368,812.1			1	368,812.1						
Дүн	4	400,820.3			1	368,812.1	3	32,008.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сантай холбоотой	1	-					1	
Дүн	1	-					1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

